

## РАШААН ХАДНЫ АРАБ БИЧЭЭС

Ц.БАТТУЛГА<sup>1</sup>, Ё.АЛТАН<sup>2</sup>, Б.АЗЗАЯА<sup>3</sup>

<sup>1</sup>МУИС, ГХСС, Түрэг Судлалын тэнхим  
ts\_battulga@yahoo.com

<sup>2</sup>МУИС, Араб хэлний багш

<sup>3</sup>МУИС, ГХСС, Түрэг Судлалын тэнхим

*Түлхүүр үг: Хэнтий аймаг, Батширээт сум, Рашаан хад, араб, перс бичээс*

**Өгүүллийн товч агуулга:** Уг өгүүлэлд Монгол нутгаас араб, перс бичгийн хэд хэдэн дурсгал олдсоны нэг болох Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хадны бичээсийн судалгаанд тулгуурлан дундад зууны үед Монгол, Араб, Перс гүрнүүдийн харилцааг цухас тодруулахыг зорьсон байна.

XIV-XV зууны үед Монголчууд Араб, Перс гүрэнтэй улс төр, эдийн засаг, соёлын өргөн дэлгэр харилцаатай байсныг түүхэн сурвалжуудаас гадна манай нутгаас олдож буй араб, перс бичигт гэрэлт хөшөөний баримт мэдээ ч нуталсаар байгаа билээ. Монгол газар, тухайлбал, их нийслэл Хархорин хотод дээрх улс гүрнүүдээс элч төлөөлөгч, худалдаачин наймаачин зэрэг лалын шашинт хүмүүс олноор ирж байсан төдийгүй өөрсдийн сүм хийд байгуулсан тухай түүхэн мэдээ бүхий гэрэлт хөшөө Өвөрхангай аймгийн Хархорин хотын Эрдэнэзуу хийдэд буй. Нийтдээ 39 мөрөөс бүтэх перс хэл бичгээрх эл гэрэлт хөшөөг хижрагийн 742 он буюу нийтийн он тооллын 1341 онд босгосон байна (Уно нар, 1999). Хөшөөний бичээснээ Аллахыг магтан шүлэглээд лалын сүм хийдийг барьж байгуулахад туслалцаа үзүүлсэн хүмүүсийн нэрсийг дурдсан байдаг.

Гэрэлт хөшөөний түүхэн бодит баримтаас үзвэл Хархорин хотод 1341 онд лалын сүм хийд баригдаж дууссан нь тодорхой байна. Нөгөө талаар тухайн үед Хархорин хотод цөөнгүй лалын сүсэгтэн амьдарч байсны гэрч юм.

Үүнийг нотлох бас нэг баримт нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг, эртний барилгын үлдэгдэл бүхий Мэлхийт толгойн орчим буюу Хархорум хотын туурь, Эрдэнэзуу хийдийн хэрмээс урагш километр гаруй зайтай газар нэгэн оршуулга илэрснийг 1980 онд малтан шинжлэхэд араб угсааны хүмүүсийн оршуулга байсан тодорхой болсон (Мэнэс нар 1989:27-30; Войтов 1990:132-149) бөгөөд малтлагаас араб бичээстэй хоёр мөнгөн зоос, нангиад бичээстэй найман хүрэл зоос олдсон бөгөөд үүнийг эрдэмтэд Жанибек хааны үе (1342-1357)-д холбогдож магадгүй (Мэнэс нар 1989:30) хэмээн үзэж байна. Эдгээр зоос ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн

олдворын санд хадгалагдаж байна. Хархорин хотоос 1342-1357 оны үед дэлдсэн зоосон тэмдэгт монгол нутгаас олдож байгаа нь тухайн үед лалын шашинт улс гүрнүүдтэй худалдаа арилжаа, соёлын өргөн харилцаатай байсны бас нэгэн гэрч баримт хэмээн үзэж болно. Монгол нутагт амьдарч байсан лалын сүсэгтний оршуулга, хөшөөний бичээс Төв аймгийн Эрдэнсант сумын нутагт буй билээ. Сэрвэнгийн Адагийн араб бичээст энэхүү дурсгалыг анх 1973 онд шинжилгээний ангид оролцож явсан проф.Ц.Шагдарсүрэн анх олж илрүүлсэн бөгөөд “Лалынхны хэрэглэдэг хижра тооллын 728 юм уу, эсвэл 827 он байна гээд одоо бидний хэрэглэж буй аргын тооллоор бол 1327-1328, эсвэл 1423-1424 он болно” (Шагдарсүрэн 1978:65) гэж үзсэн байдаг. Энэхүү хөшөөний бичээсийг бид тухайлан судалж нийтийн хүртээл болгосон билээ. Араб бичигт эл хөшөөний бүхий газар таван булш буй нь мөн л араб нартай холбогдох нь дамжиггүй юм.

Мөн түүнчлэн Чингис хааны цэргүүд Хорезмийн шах Мухаммедийн эх хатан Теркенийг олзолж улмаар Монголд авчирсан гэх ба тэрбээр 1232-1233 оны хооронд Хархорумд нас барсан гэсэн мэдээ бий (Джувейни 2004:332; Энхчимэг 2006:14). Дээрх мэдээ баримт Хархорин хот болон Монголын төв нутгаар лалын сүсэгт иргэд, худалдаачид амьдарч байсны ул мөр хэмээн үзэлтэй. Араб, перс хэлт тэдгээр улс гүрний элч төлөөлөгч, худалдаачид зөвхөн их нийслэлд ирж байсангүй, Монгол нутгаар бас аялан явж байсны нэгэн баримт нь Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Биндэр уулын зүүн урд хормойд орших Рашаан хаднаа буй араб бичээс болно.

Рашаан хадны араб бичээсийг нэрт түүхч Х.Пэрлээ олж “Рашаан хадны Олон бичээст гол хаданд 5 мөр араб (?) бичээс бий. Бичээсийг хар бийрээр хадны их барсгар толионд татлан бичсэн байна. Энэ нь монгол дахь араб бичээсний гурав дахь нь юм. Бэхний өнгө нь дээрх XV зууны монгол, нанхиад бичээсний бэхтэй ижил байна” (Пэрлээ 1974) хэмээн мэдээлсэн байдаг. Нэрт түүхч араб гээд (?) тавьсан нь араб, перс бичгийн аль нь болохыг тухайн үед тодорхой мэдэхгүйгээс тийн тэмдэглэсэн буй за. Рашаан хадны бичээсийн талаар манай оронд судалж нийтэлсэн зүйл хараахан үгүй билээ. Харин Монгол-Японы эрдэмтдийн хамтарсан хээрийн шинжилгээний анги 2005 онд үзэж судалсан гэх ба бид дээрх эрдэмтдийн судалгааг энэ удаад олж үзэж чадсангүй. МУИС-ийн МХСС-ийн багш, манжич М.Баярсайханы удирдсан Эх бичиг судлалын ангийн хээрийн дадлага, судалгааны ажлын хүрээнд 2006 онд Рашаан хадны бичгийн дурсгалуудыг тухайлан судалсан байна.

Дээрх хээрийн дадлага судалгааны ажлын хүрээнд цуглуулсан эх хэрэглэгдэхүүнээ буй араб бичгийн гэрэл болон гар зургаас (Тайлан 2006) үзвэл, уг

бичээс нь зургаан мөр, хар бэхээр татлан бичсэн ажээ. Судалгааны ажлын тайланд “Бичээсийн өндөр 27см, өргөн 29 см, мөр хоорондын зай 2 см орчим бөгөөд он цагийн уртад нар, салхи мэтийн байгалийн нөлөөгөөр зарим хэсэг нь баларч уншихуйяа нэн бэрх болжээ” хэмээн тэмдэглэсэн байна.

Он цагийн нар салхи, ус бороонд өртөн үнэхээр их баларч бүдгэрсэн тул бичээсийн мөр тус бүрийг бүрэн хэмжээгээр уншиж тайлах боломжгүй ажээ. Иймд бид бичээсийн зарим хэсгийг өөрсдийн боломжийн хэрээр тайлж унших оролдлого хийснээ толилуулж байна.

Эхийн сийрүүлгэ:

Эхийн сийрүүлгэ:	Галиг:
1. لفة ارسل ذاء خليي... .1	1. lfat 'rsal zā' hūllabī..
..... 2. سالنا حمول..... .2	2. sālanā h□amūl .....
..... 3. مجهل..... .3	3. majhal.....
..... 4. ل... و... ج..... .4	4. .... lr .... u .... j .....
..... 5..... .5	5. ....
..... 6..... .6	6. ....

Орчуулга:

1. Буцах замаар илгээв. Өвчин зовлон, хуурмаг...
2. Бид асууцгаав. Тэвчээртэй .....
3. Таньж мэдэхгүй газар .....
4. ....
5. ....
6. ....

Бичээсийн III мөрийн эхний үгийн эхний үсэг II мөрийн эхний үгтэй нэг төвшинд бичигдсэн нь тухайн бичээчийн бичих арга барилтай холбоотой байж болох ч нөгөө талаар араб бичгийн зүйд ийнхүү мөр дамнуулан бичих уламжлал байдаг билээ. Мөн III, IV мөрийн ард хэд хэдэн тамга зуржээ.

Харагдах байдал, сэргээн унших боломж зэргээс хамааран бичээсийг хэд хэдэн хувилбараар унших боломжтой юм. Хожим судлаачид дахин нягтлах буй за хэмээн найдна.

### НОМ ЗҮЙ

Баранов.Х.К., 1985. Арабско-русский словарь. М.

Войтов.В.Е., 1990. Могильники Кара-Корума, -Археологические, этнографические и антропологические исследования в Монголии. Новосибирск

Джувейни 2004. Чингисхан: История завоевателя мира. Пер. с англ. на русс. Е.Е.Харитоновна. Изд. Дом Магистр Пресс.

МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг, алтай судлалын тэнхимийн хээрийн дадлага, судалгааны ажлын тайлан, 2006.

Мэнэс Г., Баяр.Д., 1989. Два погребения монгольского времени из Кара-Корума. Түүхийн судлал, Т. XXIII, fasc. 14. УБ.

Пэрлээ.Х. 1974. Дорнод Монголын эртний бичиг үсгийн дурсгалын зүйл (Археологичийн тэмдэглэлээс). -Шинжлэх ухаан амьдрал, № 4, УБ.

Шагдарсүрэн Ц., 1978. Шинээр олдсон араб бичээстэй хөшөө, Шинжлэх ухааны Академийн мэдээ, № 2, УБ.

Энхчимэг Ц. 2006. Монголын Цагадйн улс. УБ.

Uno N., Muraka H., Matsuda K, 1999. Persian Inscription in Memory of the Establishment of a Khānqāh at Qara-qorum, -Studies on the Inner Asian languages XIY, The Society of Central Eurasian Studies.



Рашаан хадны бичээсийн гэрэл зураг

### SUMMARY

Ts.Battulga, Yo.Altan, B.Azzaya

### ARABIAN SCRIPT ON THE RASHAAN KHAD

The authors are attempting to translate the inscription of Rashaan Khad /Rashaan Rock/ as the following:

1. لفة ارسل ذاء خليى...	1. Ifat 'rsal zā' ḥullabī..
2. سالنا حمول.....	2. sālanā h□amūl .....
3. مجهل.....	3. majhal.....
4. ل... و... ج.....	4. .... lr .... u .... j .....
5. ....	5. ....
6. ....	6. ....

Translation:

1. Sent in back road. Illness, lie...
2. We asked. Restrained .....
3. Unknown land .....
4. ....
5. ....
6. ....